МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.12.31 № 53

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮН, ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД Б.ЭНХБАЯР ТАНАА

Хүний амьд явах эрхийн
хэрэгжилтийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна.

1.Сүүлийн жилүүдэд дотоодын цэргийн салбарт цэргийн албан хаагчдыг дарамтлах, зодох, эрүүл мэндэд хохирол учруулах, улмаар амь насыг нь бүрэлгэхтэй холбоотой хүний эрхийн ноцтой зөрчил бүртгэгдэх болсон нь олон нийтийн санааг зовоосон тулгамдсан асуудал болоод байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн асуудлаарх олон улсын гэрээ, Цэргийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй шууд холбоотой асуудал юм. Үндсэн хуульд заасан Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх "амьд явах эрхтэй" гэсэн заалтын хэрэгжилт ямар түвшинд байна вэ?;

2.Сүүлийн 30 жилийн хугацаанд дотоодын цэргийн салбарт амь насаа алдсан, эрүүл мэндээрээ хүнд, хөнгөн хэлбэрээр хохирсон цэргийн албан хаагчдын тоог он, анги салбар, шалтгаанаар (дарамт, зодох, осол, амиа хорлолт, бусад) ангилан гаргасан нэгдсэн судалгаа, тайлан байдаг эсэх талаар албан ёсны баримтад тулгуурласан мэдээлэл;

3.Дээрх төрлийн хэдэн хэрэгт эрүү, сахилгын хариуцлага тооцсон болон хэрэгт хяналт шалгалт, дотоод аудит хийж илрүүлдэг эсэх, мөн шүүхийн шийдвэр гарсан тохиолдлын тоо, дүн, хохирогч болон түүний ар гэрт олгосон нөхөн олговор, сэтгэл зүйн болон нийгмийн дэмжлэгийн талаар болон дээр дурдсан хүний эрхийн зөрчлүүдийн үндсэн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх талаар холбогдох байгууллагуудаас авсан арга хэмжээ, түүний үр дүнд дүн шинжилгээ хийсэн эсэх, ойрын болон дунд хугацаанд ямар бодлогын шинэчлэл хийхээр төлөвлөж байгаа талаар;

4.Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль, дүрэм, журамд оруулсан өөрчлөлт, хяналт, гомдол, мэдээлэл хүлээн авах механизм, сэтгэл зүй, хүний эрхийн сургалт, хөтөлбөрүүдийн үр дүн, үр нөлөөг үнэлсэн дүгнэлт, тайлан байгаа эсэх, цаашдын зорилтын талаарх мэдээлэл;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН С.ЭРДЭНЭБОЛД

2025000088